

**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**



**О.АЛТАНГЭРЭЛ**

## **ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуулиар хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэх, түүнийг хянан шийдвэрлэх, татан буулгах, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж ирсэн бөгөөд 28 дахь жилдээ зарчмын шинжтэй өөрчлөлт ороогүй хэрэгжиж байна. Уг хуульд 2002, 2010, 2015, 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь бусад хууль тогтоомж батлагдсантай холбогдуулан оруулсан нэмэлт, өөрчлөлт байна.

Иймд Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, шаардлага үүссэн байна. Үүнд:

#### **1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага**

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”<sup>1</sup>-ийн 1.6.38-д хуулийн этгээдийг төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлага гаргах, түүнийг хангах, хэрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ, түүнийг томилох, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалт, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

“Шинэ сэргэлтийн бодлого”<sup>2</sup>-ын Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сард багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

#### **1.2.Практик шаардлага**

Дампуурлын тухай хуулиар хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэх, түүнийг хянан шийдвэрлэх, хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, дампуурлын хэргийн гол оролцогч болох хэрэг гүйцэтгэгчтэй холбоотой асуудлуудыг зохицуулсан боловч хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх явцад практик дээр зарим сөрөг

<sup>1</sup>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтын 1.6.38-ээр баталсан.

<sup>2</sup>“Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан.

үр дагавар гарч байгаа<sup>3</sup> нь түүнийг олон улсын өнөөгийн жишигт нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагыг үүсгэж байна.

Иймд хуулийг хэрэгжүүлэх явцад практикт гарч байгаа дараах зарим хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага үүссэн. Үүнд:

1/ Төлбөрийн чадваргүй байдлыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлох, дампуурлын хэрэг үүсгэх үндэслэлийг өргөжүүлэн зохицуулах замаар хариуцагч хуулийн этгээдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх шаардлага үүссэн.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Дампуурлын тухай хуулийн дагуу хариуцагчийн өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцохоор заасан боловч шаардах эрх бүхий этгээд буюу нэхэмжлэгч нь хариуцагчийн гүйцэтгэх үүрэг түүний өөрийн хөрөнгийн хэдэн хувийг эзэлж байгааг мэдэх боломжгүйн улмаас хариуцагч өр төлбөрийн хэмжээ нь хуульд заасан хэмжээнээс давж, өөрийн хөрөнгөөс нь хэд дахин нэмэгдсэний дараа шүүхэд хандах тохиолдол гарч байна.

Тухайлбал, "Б" ХХК 1760 дахин их, "ТХ" ХХК 843 дахин их, "К" ХХК 100 дахин их өр төлбөртэй болсон хойноо шүүхэд хүсэлт гаргасан байна.<sup>4</sup>

Энэ тохиолдолд хариуцагч дахин хөрөнгөжих, үйл ажиллагаагаа цаашид хэвийн үргэлжлүүлэх ямар ч найдваргүй болохын зэрэгцээ нэхэмжлэлийн шаардлагаа хангуулах магадлал доод түвшинд очих, нэхэмжлэгчийн эрх зөрчигдөх үр дагавартай байна.<sup>5</sup>

Нөгөө талаас шүүхэд нэхэмжлэгч хүсэлт гаргах тохиолдол цөөн байгаа нь үүнтэй холбоотой байхыг үгүйсгэх аргагүй юм. 2006-2016 онд шүүхээр шийдвэрлэсэн дампуурлын 39 хэргийн хүрээнд судалгаа<sup>6</sup> хийхэд нэхэмжлэгчийн хүсэлтээр 5, хариуцагчийн хүсэлтээр 34 тохиолдолд хэрэг үүсгэн, хянасан байна.

Олон улсын стандартаар төлбөрийн чадваргүйд тооцож, дампуурлын ажиллагааг эхлүүлэх түгээмэл ашигладаг 2 төрлийн стандарт байгаа нь төлбөр төлөлтөө зогсоох тест (cessation of payment test) буюу бэлэн мөнгөний урсгал (cash flow) стандарт болон балансын тест (balance sheet test)-ийн арга байна.<sup>7</sup>

Улс орнуудын хувьд дээрх 2 стандартыг дангаар, эсхүл бусад шалгуур нөхцөлүүдтэй хослуулах замаар ашиглаж байна.

Тухайлбал, Словени Улсад үүрэг гүйцэтгэгч 2-оос доошгүй үүргийг 30-аас доошгүй хоногийн хугацаагаар хэтрүүлж, үүргээ биелүүлж чадаагүй бол төлбөрийн чадваргүйд тооцохоор заасан бол Бельги, Дани, Франц, Люксембургийн Вант Улс, ХБНГУ зэрэг улсуудын хувьд бэлэн мөнгөний урсгалын аргыг хэрэглэж байна. Тухайлбал, ХБНГУ-ын хувьд үүрэг гүйцэтгэгч өрөө хугацаанд нь төлж чадахгүй бол

<sup>3</sup>Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2016 он, "Эм Ди Эс энд Хаанлекс" өмгөөллийн нөхөрлөл, 1 дэх тал

<sup>4</sup>Мөн тэнд, 18 дахь тал

<sup>5</sup>Мөн тэнд

<sup>6</sup>Мөн тэнд, 10 дахь тал

<sup>7</sup>Мөн тэнд, 18 дахь тал

түүнийг хангалттай бэлэн мөнгөгүй болсон гэж үзэхээр зохицуулсан буюу бэлэн мөнгөний урсгалын тестийн аргыг ашигладаг байна.

Түүнчлэн, Канад, Австри, Болгар, Латви зэрэг орнуудад холимог хэлбэрийг хуульчилсан.

Үүний зэрэгцээ олон улсын чанартай эх сурвалжуудад тохиолдож болзошгүй төлбөрийн чадваргүйдэл гэх ойлголт байх бөгөөд ирээдүйд төлбөрөө төлж чадахгүй нөхцөл байдал үүсэх нь тодорхой байгаа үед ажиллагаа эхлүүлэх боломжтой байхаар зохицуулдаг байна. Тухайлбал, Их Британи, ХБНГУ зэрэг улс орныг дурдаж болно.

Түүнчлэн, төлбөрийн чадваргүйд тооцох гол шалгуур болж байгаа өөрийн хөрөнгийн талаар Монгол Улсын Дампуурлын тухай хууль болон Компанийн тухай хуульд өөр өөрөөр томъёолсон байгаа нь хэрэглэгчдийг төөрөгдүүлэх бас нэг шалтгаан болж байна.

2/Хуульд шаардлага гаргах эрх бүхий этгээд шүүхэд хүсэлт гаргахдаа хариуцагч төлбөрийн чадваргүй болсныг нотлох баримтыг ирүүлэхээр заасан ч татвар, нийгмийн даатгалын байгууллагаас нэхэмжлэгчээр оролцож байгаагаас бусад тохиолдолд нэхэмжлэгч нь хариуцагчийг төлбөрийн чадваргүйд тооцуулахтай холбогдох нотлох баримтыг олж авах боломжгүй байна.

Энэ нь шүүх баримт бичгийн бүрдэл дутуу гэдэг үндэслэлээр хэрэг үүсгэхээс татгалзах нэг шалтгаан болж байна.

Иймд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны хэргийн нотлох баримт, түүнд тавигдах шаардлага, нотлох баримт гаргах, бүрдүүлэх, цуглуулах, үнэлэх журмын талаар хуулийн төсөлд тусгайлан тусгах шаардлагатай байна.

3/Дампуурлын тухай хуулиар нэхэмжлэлийн шаардлагыг баталгаажуулах ажиллагааны талаар тусгайлан зохицуулаагүй учраас нэхэмжлэгч<sup>8</sup> нь нэхэмжлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудалд илүү саналын эрх олж авах зорилгоор нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх сөрөг практик үүссэн.

Энэ тохиолдолд шүүхээс энэхүү харилцааг тусгайлан зохицуулаагүй гэдэг үндэслэлээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг удирдлага болгон нэхэмжлэгчид шаардлагаа нэмэгдүүлэх эрхийг олгон шийдвэрлэж байна.

Үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд нэхэмжлэлийн шаардлагыг баталгаажуулах ажиллагааны талаар зохицуулалт хийж өгөх нь зүйтэй юм.

4/ Нэхэмжлэгч нарт мэдээлэл хүргэх, шаардлагаа тэгш хангуулах боломжийг олгох хуулийн зохицуулалтыг өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай байна.

Дампуурлын ажиллагааны нэг чухал хэсэг бол төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдээс авлагатай нэхэмжлэгчдийн эрхийг тэгш хангах замаар хөрөнгийг хуваарилахад оршдог бөгөөд аль болох олон нэхэмжлэгчдийг ажиллагаанд хамруулах явдал юм.

<sup>8</sup>Дампуурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Нэхэмжлэгчдийн хуралд нэхэмжлэгч бүр бүх нэхэмжлэлийн нийт шаардлагын дүнд өөрийн нэхэмжлэлийн шаардлагын эзлэх хувьтай тэнцүү саналын эрхтэй оролцоно.



Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт дурдсан тоон мэдээллээр 10 жилийн хугацаанд 39 дампуурлын хэрэгт нийт 95 нэхэмжлэгч оролцсон байх бөгөөд эдгээр нь нийт 20,7 сая төгрөгийн шаардлага гаргаснаас 1 хувь орчим нь хангагджээ.<sup>9</sup>

Үүнээс харахад нэхэмжлэгчдийн шаардлагыг хангасан байдал туйлын хангалтгүй байгаа бөгөөд дампуурлын ажиллагаанд нэхэмжлэгчид бүрэн хамрагдсан эсэх нь ч тодорхойгүй байна.

5/Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүсэх зардал, түр хэрэг гүйцэтгэгч болон хэрэг гүйцэтгэгчийн цалин хөлс, хуваарилагдах эд хөрөнгийн үнэлгээ, удирдлагатай холбогдон үүсэх зардлыг шаардах эрх бүхий этгээд шаардлагаа хэрхэн хангуулах талаар хуульд тодорхой заагаагүй учраас дампуурлын хэрэг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, ажлын хөлс тохиролцох, түүнийг төлөх асуудлаар маргаан гардаг.

Олон улсын жишгээр бол эдгээр зардлыг хэрхэн хариуцах асуудлыг урьдчилан шийдвэрлэсэн нөхцөлд хэрэг үүсгэх шаардлагыг хангалаа гэж үздэг байна.

Манай улсад хэрэг гүйцэтгэгчийг тусгай сургалтаар мэргэшүүлэн зөвшөөрөл олгож байсан бөгөөд сүүлийн жилүүдэд энэ ажиллагаа огт хийгдээгүй бөгөөд тухайн үед зөвшөөрөл авсан цөөн тооны хэрэг гүйцэтгэгч ажиллаж байна. Тухайлбал, сүүлийн 10 орчим жилд зөвхөн 5 хэрэг гүйцэтгэгч дампуурлын хэрэг тус бүрд 2-10 удаа оролцсон байна.<sup>10</sup>

Түүнчлэн Дампуурлын тухай хуулиар дампуурлын хэрэг гүйцэтгэгчийг өөрчлөх бүрэн эрхийг зөвхөн нэхэмжлэгчдийн хуралд олгосон нь зарим сөрөг үр дагавартай байна. Тухайлбал, хэрэг гүйцэтгэгчээр санал болгосон этгээд нь аль нэг талтай ашиг сонирхлын зөрчилтэй, хариуцагчийн хөрөнгийг удирдах, дахин хөрөнгөжүүлэхтэй холбоотой нөхцөл байдлыг дордуулах магадлалтай байгаа тохиолдолд түүнийг томилохоос татгалзах эрх шүүхэд байхгүй байна.

Иймд хэрэг гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, хэрэг гүйцэтгэгчээр санал болгосон этгээдийг томилохоос татгалзах эрхийг шүүхэд зохих хэмжээгээр олгох асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

6/Шүүхийн практикт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Дампуурлын тухай хуулийг давхар хэрэглэснээр ойлголтын зөрүү үүсч, маргаантай шаардлагын нэхэмжлэгчдээс илүү хураамж авч хохироох явдал гарч байна.

Тухайлбал, Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд дурдсанаар нэхэмжлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахдаа 550,250.0 төгрөг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад улсын тэмдэгтийн хураамжид 91,339, 341.0 төгрөгийг төлсөн байна.

<sup>9</sup> Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2016 он, "Эм Ди Эс энд Хаанлекс" өмгөөллийн нөхөрлөл, 13 дахь тал

<sup>10</sup> Мөн тэнд, 14 дэх тал

Иймд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд<sup>11</sup> заасан шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг нарийвчлан тусгасан байна.

7/Дампуурлын тухай хуулийн дагуу дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хариуцагч, нэхэмжлэгч, эсхүл хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр хэрэгжүүлэх боломжтой байдаг боловч практикт хэрэгжилт туйлын хангалтгүй, хариуцагчийн хүсэлтийн хувьд дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа хийлгэх замаар өөрийн үйл ажиллагааг сэргээх гэсэн зорилго тэр бүр харагдахгүй, харин татан буулгах хүсэлт давамгайлж байна.

2004 оноос 2016 оны эхний хагас жил хүртэл шүүхээс дампуурлын хэргийг хянан шийдвэрлэсэн статистик үзүүлэлтээр дампууралтай холбоотой шийдвэрлэгдсэн нийт 174 хэргийн зөвхөн 7 тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх шийдвэр гарсан бөгөөд энэ нь нийт дампуурлын хэргийн дөнгөж 4,02 хувийг эзэлж байна.

Үүнээс үзэхэд дампуурлын ажиллагааг зөвхөн өр төлбөрөөс чөлөөлөгдөх арга хэрэгсэл гэсэн агуулгаар хэрэглэх хандлага ажиглагдаж байна. Мөн 2006-2016 онд шүүхээр шийдвэрлэсэн 39 хэргийн хүрээнд хийсэн судалгаанд дурдсанаар дампууруулах, татан буулгах хүсэлт 37, дахин хөрөнгөжүүлэх хүсэлт 2 ирсэн байна.<sup>12</sup>

Төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох ажиллагаагаар 29 хэрэгт төлбөрийн чадваргүй нь тогтоогдож, 1 хэрэгт төлбөрийн чадвартай нь тогтоогдож, хэргийг хэрэгсэхгүй болгоход хариуцагч гомдол гаргасан байна.<sup>13</sup> Төлбөрийн чадвартай атлаа дампуурах хүсэлт гаргаж байгаа нь хариуцагчийг зохиомлоор дампуурах сонирхолтой байна гэж үзэх үндэслэл болохыг үгүйсгэх аргагүй юм.

Хэргийг хянан шийдвэрлэсэн байдлыг харвал татан буулгасан 32, хялбаршуулсан журмаар 4 /эвлэрсэн-1, нэхэмжлэлээс татгалзсан-3/, онцгой ажиллагааны журмаар 1 хэрэг байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлээр 1 хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

8/Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг дампуурлын хуульд илүү дэлгэрэнгүй нарийвчлан тусгаж, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой уг хуульд заагаагүй харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулах боломжийг бий болгох шаардлага үүссэн байна.

Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүсэлтээр үүсдэг онцгой ажиллагааны хэсгээр зохицуулагдаж байна.

<sup>11</sup>Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Шүүх эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2011 оны 44 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>12</sup>Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2016 он, "Эм Ди Эс энд Хаанлекс" өмгөөллийн нөхөрлөл, 12-13 дахь тал

<sup>13</sup> Мөн тэнд

Гэтэл дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх онцгой ба ердийн ажиллагааны аль алиных нь шинжийг агуулж байна. Тухайлбал, онцгой ажиллагааны *ex officio* шинжийн зэрэгцээ ердийн ажиллагааны мэтгэлцэх шинжүүд ч илэрдэг.

Шүүгч нарын хувьд ч дампуурлын хэргийг шийдвэрлэхдээ Дампуурлын тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх байдал нэг мөр болоогүй байна. Тухайлбал, шүүх нэхэмжлэлийг хүлээн авахдаа иргэний хэрэг 7, дампуурлын хэрэг 32-ыг үүсгэж, хэргийн оролцогчдод эрх, үүргийг тайлбарлахдаа 30 хэрэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг, 6 хэрэгт Дампуурлын хуулийг тус тус үндэслэсэн байна.

9/Дампуурлын тухай хууль нь батлагдсанаасаа хойш 28 жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд хуульд бие даасан нэмэлт, өөрчлөлт орж байгаагүй нь хуулийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өнөөгийн аргачлал, стандарт, зарчмуудын дагуу шинэчлэн сайжруулах шаардлагыг мөн үүсгэж байна.

Бодит байдал дээр төлбөрийн чадваргүй болсон эсэх нь тодорхой бус байдлаар иргэний эрх зүйн үүрэг, хариуцлагаа умартах явдлыг эрх зүйн арга хэрэгслээр таслан зогсоохгүй байгаа нь өрийн сүлжээ үүсгэх, эдийн засгийн харилцаан дахь итгэлцлийг бууруулах зэрэг сөрөг үр дагавартай юм.

Олон улсын эрх зүйн түвшинд дампуурлын харилцааг үзэл баримтлалын нэг чиг хандлага, төсөөтэй байр суурь баримталсан нэгдмэл зохицуулалттай болгохыг зорьж байгаа бөгөөд НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс /UNCITRAL/-оос 2004 онд Дампуурлын хуулийн гарын авлагыг боловсруулсан бөгөөд хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудад дампуурлын хууль тогтоомжоо шинэчлэх, үзэл баримтлалаа боловсруулахад суурь болгон ашиглах тулгуур баримт бичгийн нэгт зүй ёсоор тооцогдож байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ болон олон улсын байгууллагын зөвлөмж, дотоодын судалгааны байгууллагуудаас гаргасан санал, зөвлөмжийг үндэслэн 1997 онд батлагдсан.

### **Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12-т “Энэ хуулийн 22.1.3-т заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр боловсруулж батлах бөгөөд хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгана.” гэж заасны дагуу Дампуурлын тухай хуулийн нэрийг Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль гэж өөрчилнө.<sup>14</sup>

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслөөр хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгах, төлбөрийн чадвартай боловч санхүүгийн хүндрэлд орж, төлбөрийн үүргээ зогсоосон хуулийн этгээдэд төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх бүтцийн өөрчлөлт хийхтэй холбоотой харилцааг зохицуулна.

<sup>14</sup> Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

Хуулийн үйлчлэх хүрээний хувьд хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүй болохтой холбоотой харилцааг зохицуулах бөгөөд банкны системийн онцлогоос шалтгаалан банкны дампуурлын асуудал энэ хуульд хамаарахгүй байхаар, салбарын онцлогоос шалтгаалан даатгал, банк бус санхүүгийн байгууллага зэрэг санхүүгийн байгууллагын хувьд дампууралтай холбоотой нарийвчилсан харилцааг тус тусын хуулиар, нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулахаар тусгана.

Хуулийн төсөл дараах агуулгатай байна. Үүнд:

1/Хуулийн төслийн нийтлэг үндэслэл хэсэгт хуулийн зорилго, хамрах хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, хэргийн оролцогч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нийтэд мэдээлэх, гомдол гаргах процесс ямар журмаар хэрэгжих зэрэг хуулийн ерөнхий зохицуулалтыг тусгана.

2/Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх үндэслэл, шүүхэд хүсэлт гаргах этгээд, хүсэлтийн хэлбэр, агуулга, хүсэлтийг хүлээн авах, хүлээн авахаас татгалзах, хүсэлт гаргах үүргээ зөрчсөн этгээдэд оногдуулах хариуцлага зэрэг шүүхээс төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх хүртэл хугацаанд авах арга хэмжээг нарийвчлан зохицуулна.

3/Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлага гаргах хугацаа, шаардлагын бүртгэл, маргаангүй шаардлага, маргаантай шаардлага, бусад шаардлага, тэдгээрийн дүнг тогтоох, нэхэмжлэлийн шаардлагыг хангах, шаардлага хангах дараалал, хэсэгчилсэн, эцсийн болон нэмэлт хуваарилалт хийх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулна.

4/Нэхэмжлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, хурал зарлах, хуралд оролцох саналын эрх, хурлын шийдвэр, нэхэмжлэгчдийн зөвлөлийн асуудал, хэрэг гүйцэтгэгч, түүний бүрэн эрх, хэрэг гүйцэтгэгчийг томилох, солих, чөлөөлөх асуудал, хэрэг гүйцэтгэгчийн ажлын хөлс, зардал, хэрэг гүйцэтгэгчийн хариуцлагын асуудлыг дэлгэрэнгүй зохицуулна.

5/Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлсний үр дагаврыг нарийвчлан зохицуулах бөгөөд үүнд хариуцагчийн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах эрх хэрэг гүйцэтгэгчид шилжих, хариуцагчийн байгуулсан хэлцлийн талаар хэрэг гүйцэтгэгчийн авах арга хэмжээ, хүчин төгөлдөр бус хэлцэл, түүний үр дагаврын талаар зохицуулна.

6/Хуваарилагдах хөрөнгө, түүний бүртгэл, хуваарилагдах хөрөнгийг хамгаалах, нэхэмжлэлийн шаардлагатай харьцуулах, мөнгөн хөрөнгө болгох, барьцааны зүйлийг худалдан борлуулах зэрэг асуудлыг тусгана.

7/Хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөг хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон асуудлыг нарийвчлан зохицуулна.

8/Төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх бүтцийн өөрчлөлтийн ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргах, хүсэлтийн хэлбэр, агуулга, хүсэлтийг хүлээн авах, хүлээн авахаас татгалзах, үүргийн гүйцэтгэлийн хойшлуулах арга хэмжээ авах хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх, бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний агуулга,



төлөвлөгөөг хэлэлцэх, батлах зэрэг шүүхээс төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх бүтцийн өөрчлөлтийн ажиллагаа дуусгавар болох хүртэл хугацаанд авах арга хэмжээг нарийвчлан зохицуулна.

9/Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Зах зээлийн эдийн засгийн нэг үзэгдэл болох төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг зохицуулсан олон улсын жишигт нийцсэн үр дүнтэй хууль, эрх зүйн орчинг бүрдүүлснээр хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой эрх зүйн зохицуулалт илүү боловсронгуй болж, хуулийн этгээд болон иргэд, хөрөнгө оруулагчийн хооронд өрийн сүлжээ, дарамт үүсэх явдлыг тодорхой хэмжээгээр хязгаарлах, санхүү, зах зээлийн харилцааны ил тод байдал, хариуцлага сайжирч, ажилгүйдлийг бууруулах, бизнес эрхлэлтийг дэмжих, түүнчлэн нийт эдийн засгийг цэвэршүүлэх ач холбогдолтой юм.

Төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг зохицуулсан үр дүнтэй хууль, эрх зүйн орчин нь санхүүгийн дэд бүтцийн гол чухал хэсгүүдийн нэг гэж тооцогддог ба энэ тогтолцоог сайжруулснаар хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулан санхүүгийн салбарыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

### **Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна.

Дампуурлын тухай хуулийг шинэчлэн найруулж байгаатай холбогдуулан 1997 онд батлагдсан Дампуурлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Түүнчлэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд тус тус нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Харин хуульд хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан дараах хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. Үүнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Арбитрын тухай хууль, Ахмад настны тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Векселийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль, Компанийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Нөхөрлөлийн



тухай хууль, Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Улс төрийн намын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Эрүүгийн хууль.

---oOo---